



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 8/03

Арвайхээр сум

Албан тушаалын тодорхойлолт батлах
тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 526 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолын 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Худалдан авах ажиллагааны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Хуулийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн мэргэжилтэн (Б.Баттөр)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ИДЭРСАЙХАН



622240001